

**АКАДЕМИЧ Б.РИНЧЕН БАГШТАНЫ ЭРДЭМ
БҮТЭЭЛИЙН ТОЙМ**

С.Дулам
/МУИС/

Нэхэн дурсахад нэн гэгээлэг багын нэгэн дурсамжийг татан гаргаж ирвэл соньхон байх болов уу хэмээн санасаар үүнээс эхэлж тэрлэв. 1964 оны орчим үе, Баянхонгор аймгийн Байдрагийн долоон жилийн сургуулийн 6-р ангийн сурагчид бид олон сайхан зохиолыг нь уншиж, ухаант мэргэн үгсийг нь ам дамжуулан хэлэлцэж, бахдан биширдэг их эрдэмтэн Ринчен аругайд хөвгүүд голдуу хэдэн сурагч хоорондоо хэлэлцэж, амьхандаа их л тунгаан бодож байгаад нэгэн захидал бичиж илгээсэн билээ. Тэр аугаа их хүнд бидний хэдэн бөөдий сурагчийн бичсэн захиа хүрсэн эсэхийг ч бүү мэд, тэгсхийгээд мартчихсан байж. Захианы гол утга нь “явал Тан шиг олон хэлтэй, их эрдэмтэй хүн болж болох бол” гэсэн шиг утгатай л юм байсан санагдана. Гэтэл хаврын нэг өдөр манай ангийнхан хоорондоо нэг зүйлийг булаалдаад, овоорч шаваарч уншаад байхлаар нь өнгийн үзвэл өнөө бидний явуулсан захианы хариу хүрээд ирсэн юм санж. Нүүртээ монгол бичигтэй судрын зурагтай ил захидлын нөгөө талд нь бидний хаягийг бичсэний дээр “ном зохиолтой сайн нөхөрлөж, их хичээнгүйлбэл, эх орондоо хэрэгтэй тустай хүн болно доо” гэсэн утга бүхий настай хүний гарын хэв бүхий бичигтэй захиа байж билээ. Бидний хамгаас их бахадсан зүйл бол ийм алс хязгаарын хөдөөгийн сургуулийн хэдэн жулдырай сурагчдад тэр аугаа их хүнээс хариу захиа тоож ирүүлдэг нь гайхам байлаа. Бид хэд тэр захиагаа элэг зүрх мэт хайрлан нандигнаж, ээлжлэн өвөртөлж унтах нь халаг байгаад сүүлд хэнд маань хоцорсоныг ч одоо хэлэхэд бэрх болжээ. Сүүлд сонсох нь ээ бид мэтийн хүүхдүүд их эрдэмтэнд арвин их захиа бичдэг байсан агаад тэр болгонд хариу илгээдэг байсан гэх. Энэ бол их эрдэмтний гэгээн зан төрхийн нэгэн зурвас болой.

Ринчен багштан маань хэл шинжлэл, уран зохиол судлал, ардын билиг зүй, угсаатны зүй, монгол нэр томьёо судлал, монгол бөө мөргөл судлал, монгол шашин судлал, түүх судлал, урлаг судлал, утга соёлын өв, монгол түүхэн сурвалж судлал зэрэг шинжлэх ухааны олон салбарт их бүтээл туурвисан гайхамшигт эрдэмтэн болох тул тэр болгоныг нэгэн удаагийн илтгэл өгүүлэлд багтаан гүйцээх боломжгүй агаад зарим чухал бүтээлээс нь цухасхан өгүүлье. Эдгээр бүтээл нь монгол, орос, англи, франц, герман, польш, мажаар, чех хэлээр нийтлэгдсэн билээ.

Түүний бичсэн 1100 гаруй тал хуудас “Монгол бичгийн хэлний зүй” (1956) хэмээх дөрвөн боть зэрэг горилсон бүтээлээ уламжлалт ёсыг баримтлан авиан зүй, үгийн зүй, өгүүлбэрийн зүй гэж гурав ангилан судалжээ. Удиртгал хэсэгт монгол

хэл аялгууны учрыг тайлбарласан бөгөөд монгол хэлийг Ч авиатай хэл, Ш авиатай хэл, С авиатай хэл хэмээн гурав ангилжээ. Тухайлбал, дагуур хэлийг Ш авиатай хэл гэж үзсэн байна. Монгол үгийн зүйлийг урьд аймаглан хэвшсэн ёсыг шууд таягдаж, орос хэлний зүйн загварыг хүн хорхойчлон дуурайсан зүйл гэж үзжээ. Үгийн аймгийг ангилан үзэхдээ оросчлон хэвшсэн аймаглалаас эрс ялгаатай, нэрийн ай, үйл үгийн ай, сул үгийн ай гэж гурван ангилал буй болгож, нэр үг, төлөөний нэр, тооны нэр, дагавар үгийн зүйлийг ч нэр үгийн айд багтаасан билээ. Тухайлбал, монгол хэлнээ нэр үг, тэмдэг нэрийг ялгах бололцоогүй гэж үзсэн байна. Харин нэр томъёоны хувьд өнөөгийн бидний “тэмдэг нэр” гэдгийг “хавсрал нэр” хэмээн томъёолсон бөгөөд энэ тухай өөрөө “оросоор прилагательное гэдгийг латин, орос зэрэг хэлнээс монголчилж нэрлэсэн” хэмээн бичсэн удаатай. Энэ талаар ак. Л.Лигети “орос хэлний хавсрал нэрийн хэв шинжтэй энэтхэг-европ хэлний хавсрал нэрээс, монгол хэлний хавсрал нэр тэс ондоо гэж үзэх хэрэгтэй” гэжээ. Энэ бол өмнөх нэр үгтэйгээ эр, эм, эрс хүйс, ганц, хоёр, олон тоогоор хувилан зохицдог хавсрал нэрээс огт ондоон болохыг хэлсэн хэрэг болов уу. Мөн энэ академичийн үнэлснээр “үгийн зүйн хамгийн сайхан, хамгийн сонин бүлэг зүйл нь үйл үгийн цаглан хувилах байдлыг үзүүлсэн зүйл байна. Тэр бүлэг нь монгол үйл үгийн цаглан хувилах байдлыг Монголын судлал бичигт ер урьд өмнө гараагүй бүрэн гүйцдээр, цоо шинэ сонин байдлаар үзүүлжээ. Тэр шинжлэн тогтоосон тогтолцоо нь шив шинэ зүйлээр ч барахгүй, юуны өмнө магадтай лавтай бөгөөд бүх монгол хэлний судлах ухаанд үлэмжхэн тустай юм боллоо” (Ринчен 1958, 114, 115)¹ гэсэн байна. Өгүүлбэрийн зүйн тухайд нэр өгүүлэхүүний асуудлыг ялган таньж, зөвөөр үзэнд бахархалтай” гэсэн байна. Бүхэлд нь аваад үзвэл монгол хэлний зүйн тухай монгол эрдэмтний бичсэн анхны томоохон суурь судалгаа гэдгээрээ ч, монгол хэлийг эртний Энэтхэг Банины хэл зүйн нөлөө тусгал бүхүй Төвөдийн “Сүмжүба”, “Даганжүг” хэмээх “Гучит”, “Тэмдэгийн оролгын” хэл зүйн ёсоор судалдаг, хуучин судар номын уламжлал болон XIX зуунаас хүчээ авсан Энэтхэг-Европ зүгийн хэл зүйн уламжлал, тэр дундаа орос хэлний хэл зүйн ай болгоныг монгол хэлнээс албадан шахаж гарган ирдэг ардын хувьсгалын дараах хэл зүйчдийн уламжлалыг бүрмөсөн таягдан орхиж монгол хэлнийхээ уугал байгаль жамаар нь судалсан гэдгээрээ ч цоо шинэ шинжлэл судлал болсон билээ. Ринчен багшийн хэл зүй бол монгол хэлний зөв цэвэр хэлэлцэх аман яриа болон яруу тансаг бичгийн найруулгатай найрсан зохирч байдгаараа ихээхэн шинжлэх ухаанч хэл зүй болно. Энэ шинэхэн туршилтыг түүний шавь нарын дотроос миний номын багш, профессор Чой.Лу багштан залган авч, олон үнэтэй санал дэвшүүлсэн билээ. Олон улсын монголч эрдэмтдийн II их хуралд тавьсан “Монгол хэлний тийн ялгалын тухай”, мөн III их хурал дээр тавьсан “Монгол хэлний туслах үйл үгийн тухай”, V их хурал дээр тавьсан “Монгол үгийн язгуур” зэрэг илтгэл нь үүнийг гэрчилнэ.

Академич Б.Ринчен монгол ардын аман зохиол, угсаатны зүй, бөө мөргөлийн дурсгалыг судлахад олон жилийн хөдөлмөрөө зориулсан юм. Ринчен багш маань ардын оньсого, зүйр цэцэн үг, үлгэр тууль зэрэг аман зохиол, бөө мөргөлийн үлэмж

¹ Ринчен Б. *Баруун этгээд зорчсон тэмдэглэл* (Мажар улсаар явсан минь). Улаанбаатар, 1958, 209 т.х.

эх хэрэглэхүүнийг цуглуулснаа “Монгол аман зохиол”² гэсэн нэрээр дөрвөн дэвтэр болгож Герман улсын Висбаден хотноо хэвлүүлсэн нь дэлхийн монголч эрдэмтдийн анхаарлыг монгол аман зохиолын зүг хандуулахад чухал ач холбогдолтой ажил болсон юм. Тухайлбал, бидний судалдаг монгол домог зүйн талаар л гэхэд “*Монгол ардын аман зохиол*”³ хэмээх цуврал эмхэтгэлдээ (“*Тэнгэрийн замын учир*”, “*Хүн нүцгэн, нохой үстэй болсон учир*”, “*Үхрийн бөөрний учир*”, “*Ертөнцийн гурван их саналтан*”) зэрэг од гарагийн болон бүтээл туурвилын домгийг ардын үлгэрчдээс сурвалжлан цуглуулж нийтлүүлсэн юм. Мөн “*Монгол бөө мөргөлийг судлах эх хэрэглэгдэхүүн*” [Rintchen III, 1975, 188-195]⁴ хэмээх бүтээлд нь эртний домог зүйн болон бөөгийн домог зүйн холбогдолтой яруу найргийн зүйл, дуудлага, тамлага, өчил, сацал зэрэг орсон байна. Энэ гурван ботийн эхнийх нь гар бичмэлийн эх сурвалжууд болох бөгөөд олонх нь хожим үрэгдэж үгүй болсон нэн ховор эх сурвалжуудыг латин галигаар галиглан хэвлүүлжээ. “Монгол бөө мөргөлийг судлах эх хэрэглэхүүн” хэмээх гурван ботийн хоёрдугаар боть нь буриад бөөгийн эх бичвэрүүд бөгөөд өнөө цагт олдохуйяа бэрх болсон дурсгалууд байна. 1996 онд Буриадын Улаан-Үдэ хот, Байгаль далайн хөвөөнд болсон “Төв Азийн бөө мөргөл” олон улсын эдэм шинжилгээний хурлын үеэр Ри багштаны энэ бүтээлийг бүтнээр нь буриад кирил үсгээр хөрвүүлэн “Хүхэ мүнхэ тэнгэри” (Улан-Удэ, 1996) нэртэй түүвэр болгон хэвлүүлсэн билээ.

“Монгол бөө мөргөлийг судлах эх хэрэглэхүүн” хэмээх гурван ботийн гуравдугаар боть нь монгол бөөгийн эх бичвэрүүд бөгөөд энд монгол худам болон тод үсэг, төвөд үсгээр буй эх бичвэрүүдээс гадна голдуу олон монгол угсаатны бөө нэрээс янз бүрийн цаг үед бичиж тэмдэглэж авсан 126 дуудалга, даатгал, айладхал, залбирал, өчиг, сацлын үг, тамалга, сэржим, шившлэг, хурайлга, зүхэл, ураа дуудалга зэрэг бөөгийн аман яруу найргийн олон төрөл зүйлүүд багтсан байна. Энэ бүтээлийг Францын монголч эрдэмтэн Мари-Доминик Эвен франц хэлээр орчуулан судалж, “Монгол бөөгийн дуудалга” нэртэй нэг сэдэвт зохиол бичиж, докторын зэрэг хамгаалсан бөгөөд “Монгол Сибирийн судлал” цувралын 1988-1989 оны 19-20-р боть болж хэвлэгдсэн байна.

Академич Б.Ринчен эл арвин баялаг эх хэрэглэхүүнийг хээрийн шинжилгээний ангиар явах үедээ тэр цагийнхаа сайн бөө нарын амнаас сурвалжлан тэмдэглэж авснаас гадна орон шоронд орсон үед нь ч элдэв аргаар тэтгэн тусалж итгэлийг олоод үг алдуулж чаддаг хосгүй уран аргатай байжээ. Монгол бөө нар өөрсдөө Ри багшийг дээд Хурмаст тэнгэрийн аль нэгнийх нь илгээсэн биет элч хэмээн итгэж, юугаа ч нууцлалгүй харамгүй хэлж өгдөг байсан нь ийм их амжилтад хүрэхийн үндэс болжээ. Дээрх цуглуулгын гуравдугаар ботид орсон аман эх бичвэрийн зарим хэсэг нь юу юугүй бөөгийн онгод орох гэснээс болоод дутуу орхисныг тэмдэглэн үлдээсэн нь үүний нэгэн гэрч юм. Түүгээр ч барахгүй, Дамдин зааринг

² Rintchen. Folklore Mongol. Asiatische forschung. Bd 7.11. 12. 15., Wiesbaden: Harrassowitz, 1960. 1963. 1964. 1965., Rintchen. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. Asiatische forschung. Bd 8. Wiesbaden: Harrassowitz, 1961

³ Rintchen B. Folklore Mongol. - *Asiatische Forschungen*. Bd 7, 11, 12, 15, Wiesbaden: Harrassowitz, 1960, 1963, 1964, 1965 [Rintchen 1960, 1963, 1964, 1965]

⁴ Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. III. Textes chamanistes mongols. Wiesbaden: Otto Harrassowitz, 1975, 151 p. [Asiatische Forschungen, Band 40] [Rintchen III, 1975]

дагуулан Энэтхэгт олон улсын хуралд очсон баримтыг түүний үр хүүхэд нь дурсан ярьж байна.

Ринчен багштан бүр 1928 онд орон нутагт хээрийн шинжилгээний ажлаар Булган аймгийн Хутаг сумын нутаг Гучингурт, Гурван Хайлантайд Сулхарнай баатар хэмээх онгодыг сүлдлэн тахидаг нэгэн халх зааринтай уулзсан хийгээд тэр бөө өөрөө Сулхарнай баатар хэмээгч нь чухам ямар түүхтэй онгод болохыг мэдэхгүй байжээ. Үүнийг Ри багш дараа дараагийнхаа судалгаагаар тодруулж, Сулхарнай баатар бол эртний Грекийн хаан, Дундад болон Баруун өмнөд Азийг байлдан дагуулагч Македоны Александр мөн болохыг нэхэн тодруулсан байдаг. Энэхүү халх зааринтай анх 1928 оны зун Сэлэнгэ мөрний Гуртын тавилан дээр уулзаж яриаг нь тэмдэглэн авсан тухайгаа түүхч О.Пүрэв агсанд 1967 онд ярьж байжээ (Билгүүн номч Б.Ринчен 1990, 69)⁵. Ринчен багшийн “Монголын бөөгийн шажинг судлахын хөтөлбөр” нэртэй 19 тал хуудас 427 асуулттай эх хэрэглэхүүнийг 1997 оны 6-р сарын 23-нд оточ маарамба Батын Пүрэвсүрэн аругай надад өгсөн бөгөөд 1967 оны орчим Ри багштан түүнд нэг хувийг өгсөн байжээ. Энэ тухай миний бие 2005 онд 100 жилийн ойд нь зориулсан эрдэм шинжилгээний хуралд тусгайлан илтгэл тавьсан тул дэлгэрүүлэн ярихгүй.

Домог зүйн судалгааны хувьд академич Б.Ринчен домгийн үйл явдал, дүрийг түүхэнд болсон явдал, түүхэн хүний дүртэй харгалзуулан үзэх гэсэн эвмегерч маягийн үндэслэл боловсруулж байв. Тухайлбал, буриад домгийн Эсэгэ Малаан тэнгэрийн дүр бол үнэн хэрэгтээ Чингис хааныг тэнгэрчилсэн хэрэг гэж үзэж байв (Ринчен 1975, 188-195)⁶.

Аман зохиолыг сурвалжлан цуглуулах арга зүйн хувьд манай судлаачид орон нутгаар явж үлгэрч туульч хүмүүсээс хэлүүлж тэмдэглэж авахаас гадна орон нутаг даяар алдаршсан ардын авьяас билигтнүүдийг урин ирүүлж аман зохиолын зүйлийг бичиж авч байжээ. Тухайлбал, ардын хувьсгалын дараахан Алтанбулагийн сууринд аж төрөн сууж байсан үлгэрч, туульч Өлзийн Лувсан хуурчаас “Баруун тивийг эзэлсэн Бодь мэргэн хаан” хэмээх туулийг 1927 оны 8-р сарын 9-нөөс эхлэн олон хоног сууж байж аялгууны хамт бичиж авсан нь туулийн хөг аялгууны судлалд үнэтэй өв болсон байна. 1929 оны үед Засагт ханы хүрээний халх лам, үлгэрч Дэндэвээс 14000 мөр шүлэг “Нэг зуун тавин таван насыг насалсан хөгшин Луу мэргэн хаан” зэрэг үлгэр туульсыг тэмдэглэн авсан нь энэ зуунд халх, ойрадчуудаас бичиж авсан туульсын дотор хэмжээгээр хамгийн томоохон нь байдаг. Мөн “эрхийдээ эрчтэй эрийн сайн Хамбуудай мэргэн хаан”, “Дан цагаан морьтой Дансүрэн гуйлгачин”, “Жангар” туулийн хувилбарууд зэргийг Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий, Булган, Хөвсгөл зэрэг аймгийн халх туульчдаас бичиж авсан байдаг. Энэ бүх олдвортоо тулгуурлаж, Жангар туулийг гагц Халимаг, Шинжааны ойрадууд хэлдэг биш, халхчуудын дунд нийдэм дэлгэрсэн гэсэн санааг анх хэлсэн байдаг. Мөн Гэсэр судлалын хүрээнд Гэсэрийн хамгийн томоохон

⁵ Билгүүн номч Бямбын Ринчен. Эмхэтгэж эрхэлсэн Г.Аким, “Монгол уран зохиол” хэвлэлийн газар, Улаанбаатар, 1990, 238 т.х.

⁶ Ринчен Б. *Культ исторических персонажей в монгольском шаманстве*. –В кн.: Сибирь, Центральная и Восточная Азии в средние века. –Новосибирск: Наука, 1975, с. 188-195

хувилбар “Заяын Гэсэр”, “Номч хатны Гэсэр”, “Замлин Сэнчиний намтрын”⁷ эх бичгийг хэвлүүлж, олон судлаач эрдэмтний хүртээл болгосон билээ.

Баатарлаг туульсын тухай бичихдээ “Монгол ардын баатарлаг туульсын агуулгыг нь үзвэл, цөм түүхээ бүтээгч манай ард түмний өнгөрсөн эрт цагийн түүхийг тусган үзүүлж, дээр цагт монгол овогтон буй болж, улс түмэн болж ирсэн баатарлаг тэмцлийн явдлыг яруу сайхан дүрслэл болгон найруулж, эрх чөлөө тусгаар тогтнолоо харийн дайсны халдан довтолж, түрэн эзлэгсдээс хамгаалж, ... тэмцэж байснаа магтан дуулж, ... эх орон, нутаг ус, түмэн олондоо халуун хайртай сайн баатар эр хүн бол ийм хатан зоригтой, эр чадалтай, самбаа их ухаантай, тэсвэр их хатуужилтай байдаг юм. ... Санасан газарт нь сэтгэлчлэн хүргэж, сандарсан газарт нь ухаан сэлбэдэг хүлэг сайн морь нь ийм шинжтэй байдаг юм. Зоригт эр баатрын хань нь ийм сайхан сэтгэлтэй, тийм сайхан царайтай, бат их журамтай, сод их ухаан самбаатай, хайр их халамжтай байдаг юм. Дайсан гэдэг ийм их айхтар сүртэй, сүрдэм их чадалтай, тийм их муухай санаатай, холын их хар харгис бодолтой байдаг юм. Тийм бэрх дайсныг эх орон, түмэн нь олон сайн баатар хөвгүүдийнхээ амь бие хайргүй зүтгэснээр хэзээд туулан давж, эцсийн эцэст муу муухай бүгдийг даван туулж, ... ялан давдаг ёстой юм гэж бэрхийг тохиолдох цагт зориг бадруулж, баатар айцуулын жишээгээр хүмүүжүүлдэг учраас үлгэр жишээ болох ёстой юм гэж үлгэр гэж эртнээс нааш нэрлэсээр ирсэн байна” (Ринчен 1966, 14-15)⁸ гэж бичжээ. Буриад зэрэг зарим монгол угсаатан “Тууль” гэхийн оронд “Үлигэр” гэж нэрлэдэг нь ч үүнтэй холбоотой бөгөөд ард түмний үлгэр дуурайл болсон баатрууд гардаг гэсэн үг юм. Аман зохиол сурвалжлан цуглуулдаг арга барилаас нь түүний гарын шавь Чой.Лу багштан дурсан хуучилсан нь: ...Тэгээд илүү үгтэй би гэдэг чинь бас л: «Та зуны дэлгэр цагт ирж таатай сайхан амрахгүй, баахан хүйтэн цагаар морилж иржээ дээ» гэв. Чингэтэл багштан ширвээ сахлаа ширвэн шувтарч: «Амралтанд би амрах гэж ирдэггүй, ардынхаа аман зохиол, ардын билгийн зүйлийг хотоос холхон амралтанд ирж хөдсөн дээлтнээс ардын эрдэм гэгчийг бичиж тэмдэглэж авдаг юм. Танай энд зун амардаг улс чинь бас амарч чаддаггүй, зусаг ямаа, шүдлэн ухна шиг хоёр хоёроороо Шунхлайдаад, хад чулуун дээр элдэв юм зүй бусаар эрээчээд явдаг юм» гэж айлдахад нь, би бас л буруудсанаа мэдэснийг багштан даруйхан болгоомоц, «Өвлийн цагт хол газрын амралт хүн нь ч цөөн хоол нь ч сайн байдаг гэж айлдарынхаа эрчийг зөөлрүүлэв. Хүн нь цөөн болохоороо настан өвгөд эмгэдтэй уулзан ярилцахад хөлсөх амьтан ховор, цөөн хүнтэй амралтанд дуртай хоолоо хийлгэж идээд байж болдог юм» гэж айлдахад нь яагаа ч үгүй хүний үгэнд даган хөөрдөг зантай би чинь бас л: «Ай, нээрээ тийм байх шүү. Дандаа хуушуур бууз хийлгэж идээд байсан ч болох юм даа» гэж үгстэл багштан: «Би хуушуур бууз бараг иддэггүй, одоо цагт хуушуур дотор хулгай бий, буузан дотор булхай бий.

⁷ *Say-a-yin Geser-ün tuuji*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM Tomus IX, Fasc. 2, Шинжлэх ухаан, Дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл, Улаанбаатар, 1960, 192 т.х. *CAMLING ŠENGČIN-Ü NAMTAR ORUSIBA*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM, Tomus X, Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн Хэвлэл, Улаанбаатар, 1959, 233 *Nomči qatun's version of Kesar saga*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM Tomus IX, Fasc. 4, Эрдэм шинжилгээний хэвлэл, Улаанбаатар, 1960, 192 т.х.

⁸ Ринчен Б. *Манай ардын туульс*. “Монгол ардын баатарлаг туульсын учир” номд, Эмхэтгэсэн У.Загдсүрэн, редактор С.Лувсанвандан, ШУА-ийн хэвлэл, Улаанбаатар, 1966, 127 т.х.

Би мах, шөл, гурилтай хоол гээд л задгай хоол идэх дуртайй» гэж айлдав. За би ч амаа хамхихгүй бол горьгүй нь гэж бодтол, багштан босож гарахыг завдахуйяа би: «Та манайд анх морилж ирсэн, би аяга сайхан задгай хоол хийж өгье дөө» гэтэл, «Би амралтын газар албаны хоолтой, сайн идэж салхи залгиж яваа хүн, та надад хоол хийх цагаа хятад хэлээ үзэхэд зориул даа» гэж айлдаад гарахад, би бараа болон явж амралтын өрөөнд хүргэн морилуулав» (Лувсанжав 2003, 95-96)⁹ гэсэн байдаг.

Угсаатны зүйн талаар Ринчен багштаны санаачлага болон удирдлагаар зохиосон иж бүтээл бол 1979 онд хэвлэгдэн гарсан “Монгол Ард Улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас” юм. Хоёр зуу гаруй газрын зураг болон биет зургуудаас бүрэлдсэн энэхүү атласын нэлээд хэсгийг БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр байсан эртний овог аймаг, хаант улсууд, тус орны эдүгээгийн угсаатны бүрэлдэхүүн, овгийн тархацыг харуулсан үзүүлэлтүүд эзэлж байгаа нь угсаатны зүйчид, хүн судлалтан, түүхчид, бусад олон салбарын судлаачид, жирийн уншигчдад тус болох сайхан бүтээл болжээ. Мөн тус атласт Монголд байсан бүх хүрээ хийд, жалгын дуган, сүмүүд, бархантай болон тийтэй хүрээ хийд, бичигт хад, гэрэлт хөшөөдийн байршлыг тэмдэглэсэнээрээ мэргэжлийн судлаачдад олдошгүй ховор гарын авлага, хөтөлбөр болжээ. Энэ нүсэр ажлыг бүтээсэн арга зүй нь сонин бөгөөд гадаад, дотоодын эрдэмтдийн удирдлагаар манай улсын нутаг дэвсгэр дээр 1921-1970-аад оны хооронд явсан хээрийн шинжилгээний ангиудын цуглуулсан мэдээ мэдээллээс гадна сум, орон нутаг болгонд өөрийн итгэмжит мэдээллийн эх сурвалжийг олж байршуулан тэднээс байнгын шинэ сэвүүн мэдээлэл авдаг байжээ.

Ринчен багшийн түүхэн зохиолын түүчээ нь 1945 онд бичсэн “Цогт тайж” кино тууж болно. Энэ бол санаандгүй бичсэн зохиол биш, эх орны чөлөөлөх дайны өмнөхөн “Невийн Александр” шиг чин зоригт эх орончийн тухай кино бүтээхээр зориулж бичсэн гэдэг. Уг үйл явдал нь XVII зууны үеийн Монгол, Төвөдийн түүхэнд холбогдох бөгөөд улааны шашин, шарын шашны хоорондын зөрчилд Цахарын Лигдэн хаан, Халхын Цогт хун тайж хоёр нэг тал болж, Зүүнгарын Гүш хаан Төрбайх эсрэг тал болж тулалдсан тухай өгүүлдэг. Түүхийн харгуйгаар аялж явах зуураа түүний дээд өвөг нь Халхын Цогт Хун тайжийн удам, Охин Хун тайжийн угсааны хүн болохыг олж тогтоожээ. Чингээд эрэлхэг дайчин өвөг дээдсийнхээ тухай кино зохиол туурвихаар шийдсэн хэрэг. Түмэнхэн Цогт Хун тайж бол XVI-XVII зууны үеийн улс төрийн зүтгэлтэн, бичиг номын сэхээтэн, яруу найрагч Гэрсэнзийн гуравдугаар хөвгүүн Үйзэн хааны хүү Бахарай хошуучийн гэрт мэндэлжээ. Энэ бол түүхийн сэдэвт томоохон кино туульс бүтээх анхны шилдэг сонгодог туршиц болжээ.

XIX зууны эцэс, XX зууны эхэн үеийн монгол нийгмийн жаран жилийн амьдралыг жирийн малчин Ширчингийн дүрээр төлөөлүүлэн үзүүлсэн “Үүрийн туяа” хэмээх том хэмжээний туульсын зохиол (“Манжийн талхинд” тэргүүн боть 1947 (1951) онд, “Гал усны гашуун зовлон” дэд боть 1952 онд, “Байлдаж олсон эх орон” гутгаар боть 1955 онд тус тус хэвлэгджээ) туурвижээ. Энэхүү гурамсан романд монгол нийгмийн олон анги, давхаргын төлөөлөл болсон баатруудын хувь заяаг дүрсэлжээ. Эмгэн Сүрэн, Тансаг, өвгөн Луузан, Хөвчийн хар дархан,

⁹ Лувсанжав Чой. *Насаараа дурсахуй* (ярилцлага). “Эрдмийн хэлхээ” цуврал No1, 2003, 95-108-р тал.

өвгөн Батбаяр, хүү Насанбат, Дамиран гавж, Балданчоймбол гачэн, хар Дондог лам, Жамсранжав тайж, Лодой баян гэх мэт олон сонин зан төрхтэй, сонирхолтой хувь заяа бүхүй баатрууд гардаг. Харин гол баатар Ширчин бол уг язгуурын ядуу малчин ард бөгөөд Соном зангийн зарц байснаа Богд хаант Монгол улсын цэрэгт дайчлагдаж, Да хүрээний Хужирбулангийн цэрэг болжээ. Тэндээс Хатанбаатар Магсаржавын цэрэгт элсэж, улмаар Ховдын хязгаарыг Манжийн дарангуйлагчдаас чөлөөлөх дайнд оролцсон байна. Ийнхүү тэр цагийнхаа нийгмийн олон донсолгоонт үйл явдлын амьд гэрч болж, айлын зарцаас монгол төрийн эр цэрэг, сүүлд нь улсын сайн малчин болтлоо өсөж дээшилсэн баатар болсон юм.

Ер нь уран бүтээлийн хувьд түүх соёлын нэвтэрхий их мэдлэгээ ашиглан монголчуудын өвөг дээдсийн балар эртний аж төрлөөс эхлэн өөрийн төрж мэндэлсэн цагийг хүртэлх аугаа их түүхэн туульс бүтээхээр зорьж байжээ. Тухайлбал, балар эртний хүний ан агнуурын соёл, нум сум хэмээх шинэ зэвсэг үүсэж гарсан болон галын шүтлэг тахилга, овог аймгийн зохион байгуулалтыг урнаар дүрсэлсэн “Заан Залуудай” романаа туурвисан бөгөөд зохиолын гол баатар нь Чонос овгийн өндөр их дээдэс Шонхолой, түүний идэр залуу хөвгүүн Залуудай, түүнтэй санамсаргүй уулзан танилцсан Бай-күл нуур хавиар нутагтай, Ихэрэс ясны Бух өвгөн хэмээх гурван хүний аяллын тухай өгүүлдэг. Энэхүү зохиол нь овог хоорондын дайсагнал, догшин араатан амьтадтай хийсэн аюумшигт тулаан, хүний мах хүнсэлдэг Шар махчингуудын тухай зэрэг сонирхолтой үйл явдлаар дүүрэн. Залгаад түүний бичсэн томоохон зохиол бол ЗТӨ III зууны үеэс Төв Азид мандаж байсан Наран эхт Саран эцэгт Хүн улсын түүхэнд холбогдох “Их нүүдэл” хэмээх романы тэргүүн дэвтэр (1969) болно. Хүн гүрний ирээдүйн эзэн Модун шаньюй харь дайсан гүрний барьцаанд байхдаа “Төрийн төлөө төрлийг тэвчих” гэсэн догшин хатуу тангарагтай болж, Түмэн шаньюйг хөнөөсөн тухай, хятадын Чин улсыг үндэслэгч Циньши хуанди Түмэн газрын цагаан хэрмийг Хүн улсын нутгаас таслан авч, үргэлжлүүлэн барьж байгуулсан тухай, Дунху-г дайлаар мордох болсон учир шалтгаан зэргийг нанхиад сударч Сыма Цяний “ШиЖи” буюу “Түүхэн тэмдэглэл” зохиолоос санаа авч бичжээ. Хүн улсын дайчин эрсийн чин зориг, өнгийн бэлгэдэлт морин цэргийн жагсаал, цэргээ аравт, зуут, мянгатаар зохион байгуулдаг байлдааны урлаг зэргийг “Баруун Хан улсын түүх” сурвалжаас сэдэвлэн авсан байна. Эртний улсуудын соёлын харилцааны тухайд Торгоны замаар түгэн дэлгэрсэн Кушан, Грек соёлын үндэс дамжлага, эртний нүүдэлчид Грекийг Эллин улс, Африк тивийг Хөөст тив хэмээн нэрлэдэг байсан тухай өгүүлжээ. Эртний түүхтэй холбоотой эдгээр романаа угтуулан “Сандо амбан” хэмээх бичил романаа туурвисан билээ. Манж төрийн зараалаар ирсэн сүүлчийн энэ амбан нь дорно зүгийн бичиг соёлд нэвтэрхий бичгийн угтгач байсан тухай ч өгүүлсэн байдаг.

Б.Ринчен багштан бол 1960-аад оны өгүүллэг туурийн нэрт уран дархны нэг юм. Чингэхдээ түүхэн туурийн /историческая новелла/ уран дархан гэвэл илүү оновчтой билээ. Түүний түүхэн тууриуд нь эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн монголын ард түмний эрэлхэг баатрууд, монголын урлаг соёлын гарамгай зүтгэлтнүүд, тэдний бүтээлч үйл ажиллагаанаас сэдэвлэн авсан байдаг. Тухайлбал: “Ану хатан”, “Нууцыг задруулсан захидал”, “Сүүлчийн хичээл”, “Гүнж”, “Шүхэрч Буньяа”, “Бадарчин” зэрэг түүхэн туурь бий. “Ану хатан” түүхэн туурь XVII зууны

дунд үед Зүүнгарын хаант улсыг нэгтгэн байгуулж, Манжийн булаан эзлэгчдийн эсрэг тэмцэж байсан баруун монголчуудын тэмцлийг тусгасан байна. Энэ туурь ардын түүх, домог, хууч ярианд үндэслэж түүхэн үйл явдал, түүхт хүмүүсийн дүрийг уран сайхны дүр, ургуулан бодох бодлоор “буйлуулан” тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн эрэлхэг баатрууд, ард түмний нугаршгүй хатан зоригийн тухай өгүүлсэн байдаг. Туурийн гол баатар Ану хатан харийн булаан эзлэгчдийн эсрэг тэмцэж буй өөрийн нөхөр Галдан бошигтын үйл хэргийг дэмжиж, аян дайны хүнд цаг үеийг толгой гудайж, сэтгэл гансралгүй туулж, эр нөхрөө үнэнч ханийн ёсоор халамжлан, хатамжилж байдаг. Зохиолч Галдан бошигтын дүрээр Дорно дахины гүн ухааныг нэвтэрхий судалсан эрдэмтэн, улс орныхоо тусгаар тогтнолын төлөө мохошгүй хатан зоригийг барин тэмцэгч, цэргийн жанжин, Манж дайчин улсын монгол угсаатныг уусган эзлэх гэсэн улс төрийн заль мэхийг гүнээ ухаарсан, төрийн мэргэн бодлоготон гэдгийг дүрсэлсэн байна. Энэ зохиолын бусад баатар тухайлбал, Чинбай баатар ард түмний баатарлаг тэмцлийн амьд биелэл болсон жинхэнэ ардын баатрын дүрийг бүтээх гэж зорьсон ажээ. Галдан уг нь Зүүнгарын ноёны заль мэхэнд автаж, Төвөдийн гурван хийдэд Бурхны шашин, гүн ухаанд суралцахаар төрсөн нутгаасаа алс газар зайлуулагдсан хүн юм. Энэ хооронд түүний төрсөн ах, зориг шийдвэр муутай, хулчгар Сэнгэ ноёныг Зүүнгарын зайсангууд хаан ширээнд суулгажээ. Гэвч Зүүнгарын ноёдын дунд хагарал болж хаан төр эзгүйрэхийн хамт, элч буухиа довтолгон Зүүнгарын зайсангууд Галдан бошигтыг хаан ширээндээ эргэн залрахыг гуйж байна. Гэвч Галдан бошигт үүнийг үл сонирхон, татгалзсан боловч, эцэг хааны шадар Чинбайн айлтган өргөсөн эх нутгийнх нь ганц атга агь, идэр залуудаа хайр сэтгэлтэй явсан Ану гүнжийн захидал хоёрыг авсан мөчөөс эхлэн, Төвөдийн номын их хийдийн ширээт болох хувь заяанаасаа татгалзаж, эх нутгийн зүг яаравчлан эргэж, Ойрад, Зүүнгарын хаан ширээг авсан байна. Энэ үеэс эхлэн Галдан бошигт Манжийн булаан эзлэгчдийн хамгийн гол дайсан болно. Энэ туурьд Галдан бошигтын бүх тулалдааны тухай биш, харин Манжийн цэрэгтэй тулалдсан сүүлчийн /1696/ Зуунмодны тулалдааны тухай өгүүлдэг. Манжийн цэрэг сэхээ зав өгөлгүй Галдан бошигтыг мөрдөж байлаа. Галдан хүрээ байгуулж, Манжийг тосож байлдахаар зэхэж байв. Ану хатан энэ тулалдаанд эртний монгол дайчдын уламжлалаар хүлэг мориныхоо толгойд марал буюу бугын баг хийж өмсгөөд, манжийн цэргийн бүслэлтээс Галдан бошигтыг, нөхдийн хамт аварч гаргаад өөрөө амь үрэгддэг. Энэ бүгдээс үзвэл Ану хатан, чин зориг, үнэн журмын хөрөг бэлгэдэл (icon) болсон баатар хүн.

Мөн “Нууцыг задруулсан захидал” туурийн гол баатар нь Ойрадын дайчин эр Гөлөгдэй, түүний хүү Шонуу нар юм. Зохиолын үйл явдал Манжийг эсэргүүцсэн тэмцлийн эхний шатанд болсон үйл явдал юм. Ойрадуудын замд Орхон гол үерлэсэн нь нэгэн хэсэг саатахаас өөр аргагүй болсон ажээ. Энэ үед Ойрадын жанжин Чорос овогт Гөлөгдэй баатар Энх-Амгалан хааны бие төлөөлөгч манжийн Фү жанжинтэй холбоо байгуулж найрсаг нөхөд болжээ. Ардын дунд шулуун шударга, цэх журамтай гэж алдаршсан баатар дайсантай шадарласан нь олон түмний эгдүүцлийг төрүүлэн цуу үг ч гарчээ. Нэг өдөр Фү жанжин шадар цэргээ дагуулан Гөлөгдэй баатрын өргөөнд зочлохоор иржээ. Гол өргөөнд монголын уртын сайхан дууны эгшиг уянгалж байхын хамт цэргүүд Фү-ийн тушаалаар

Гөлөгдэй баатрыг Шонуу хүүтэй нь баривчлан, Ойрад цэргийг бүслэн эзэлжээ. Уг нь энэ үед Гөлөгдэй баатар Фү жанжинг урьж найрлаад тусгай дохиогоор баривчлах ёстой байжээ. Гэтэл өөрөө баригдсан нь урвагчийн харгайгаар нууц нь дайсанд мэдэгдсэнээс болжээ. Гөлөгдэйн жинхэнэ захианы оронд хуулбар өгснийг идэр залуу Шонуу мэдсэнгүй. “Элчийн үг аманд гэдэг” эртний мэргэн үгийг залуу хүү эс хайхарснаас ийм их эндэл осол гарчээ.

Фү жанжин хуйвалдаанд оролцсон бүх хүмүүсийг удам угсаагаар нь хүйс тэмтрэх, Гөлөгдэйн гал голомтыг устгах зарлиг буулгажээ. Цаазын үед Гөлөгдэй – хүүгээ амьд үлдээгээч! гэсэн цорын ганц хүсэлтийг тавьж байна. Фү жанжин энэ хүсэлтийг “амьд үлдэх Шонуу эх, эцэг, дүү нараа цаазлах” болзолтойгоор биелүүлэх болно гэж хүлээн авч байна. Эцэг, эхийнхээ гуйлт учирлалын эцэст Шонуу эцгийнхээ зэвсэгт, эхийн хормойд сөхөрч мөргөөд аав, ээж хоёроо цаазалдаг. Мөн адил хоёр бүсгүй дүүгийн толгойг авч байна. Гөлөгдэй, Шонуу нарын дүр бол тусгаар тогтнолын төлөө тэмцэгч хамгийн эрэлхэг зоригтны дүр болжээ.

Зохиолчийн “Гүнж” туурь Манжийн эсрэг үзэл санаатай монголын нэгэн ноён Дархан чин ван Дондовдоржийн манж угсааны хатан Хичээнгүй Амгалан гүнжийн тухай түүхэн баримтанд дулдуйдан бичжээ. Монголын ноёдыг улс төрийн хувьд хараат байлгахын тулд манж нар тэдэнд зэрэг хэргэм олгох, хээл хахууль цутгах, охид гүнжээ өгч хүргэн тавнан болгох башир арга хэрэглэж байв. Хичээнгүй гүнж Дорно дахины төгс эрдэм боловсролтой эртний Төвөд, Манж, Хятадын түүх, гүн ухаан, яруу найргийг сайн мэддэг, эзэн хааны ертөнцөөс тусгаарлагдмал уйтгарт нэг хэвийн амьдралд залхаж, чөлөө жаргалыг эрмэлзсэн бүсгүй байв. Энэ бүсгүй монгол хүний гэргий болж, Монгол нутгийн сайханд бишрэн хүн ардынх нь зан заншлыг хүндэтгэн, эр нөхрийн хүсэл бодлыг дэмжин, дайснаас хамгаалагч болон хувирчээ.

Ринчен багшийн яруу найргийн туурвилууд тэр дундаа “Бэр цэцэг” найраглал нь өрлүүд овгийн өвгөд настнаас сонссон домгоос улбаатай бөгөөд Сартуул иргэнийг дайлаар мордоод эргэн ирж буй цэргийн цуваан дотроос халуун хайртаа өнжин хонон хайгаад олоогүй монгол бүсгүй өндөр дэнжийн оройд толгой гудайн бие нь хөшиж, алаг нүднээсээ нулимс цувируулан байхад *“ариун тэр нулимс унасан газар анхилам сайхан цэцэг ургасныг хөөрхий тэр бүсгүйн дурсгал болгож, хөгшид “бэр цэцэг” гэж нэрлэсэн”* тухай гардаг. Энэ бол орчин үеийн монгол уран зохиолын бэлгэдэл дүрийн нэгэн жишээ мөн бөгөөд өнгөрсөн оны 10-р сарын 25-нд “Бэр цэцгийг” “Үндэсний бахархалт цэцгээр” өргөмжилсөн нь санаандгүй учир тохиол биш бололтой. Монголчууд эртнээс нааш бэр цэцгийг эрүүл саруул, дайн дажинүй, энх амгалан амьдралын бэлгэдэл болгож ирсэн бөгөөд орон нутгийн нэр нь “баавар цэцэг”, “тосон тором” гэдэг. Гадаад төрхөөрөө монгол эмээлийн бааврыг санагдуулам уран гоёмсог, Монгол орны бүх нутгаар нийдэм тархан ургаж, зуны гурван сарын турш цэцэглэн цэнхэр, нил ягаан өнгөөр туяардаг билээ. Мөн түүний гадаад улс орноор аялан явах зуур бичсэн “Үдэш Невскийд”, “Геллерт ууланд” зэрэг олон сайхан аян замын шүлэг буй. Ри багшийн яруу найргийн манлай нь өнөө өглөөний хурлын нээлтийн ёслолын үеэр дуу болон дуурьссан, манай монгол угсаатны соёл оюуны дархлааг яруу сонголонт бичгийн хэлээр урлан туувисан “Монгол хэл” шүлэг билээ. Чингээд би илтгэлийнхээ өндөрлөгөөг энэ шүлгийн

*Мөрөн голын цутгалант ширгэшигүй их далай мэт
Мөнхөд үр ач нарын залгамжаар бадранхан дэлгэрч
Хөндий цээжинд орогч бүхнийг нэвтрүүлэх чадалт*

Хөгжим мэт яруу баясгалант монгол хэл мину гэсэн нэгэн утга төгөлдөр,
бадрангуй эгшиглэнт бадгаар дээшлүүлэе.

Энэ удаа Ринчен багштаны сэтгүүл зүй, орчуулгын бүтээл туурвилын зүйлийг бусад мэргэжлийн нөхдөд даатган орхиод, эрдэм судлал, уран зохиолын бүтээлийг нь голлон өгүүллээ. Эцэст нь дүгнэн үзвэл:

1. Академич Ринчен багштан бол монгол хэл шинжлэлийг монгол хэлний хууль зүй жамынх нь дагуу хөгжүүлсэн анхдагчийн нэг мөн.
2. Монгол утга соёлын үнэт өвийг насан залуугаас сурвалжлан цуглуульж, гадаад, дотоодод хэвлэн нийтлүүлж, судалгааны хүрээнд оруулан, утгынх нь чанад хязгаарт нэвтэрсэн их шинжээч билээ.
3. Орчин цагийн монгол уран зохиолын туульсын том төрөл зүйлийг үндэслэгч, түүхэн туурь зэрэг богино төрөл зүйлийг ч үүсгэн хөгжүүлэгч мөн.
4. Ринчен багштан бол манай өнөөгийн нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны олон салбарын үндэс суурийг тавьсан эрдэмтэн билээ.
5. Монголын орчин үеийн шинжлэх ухааныг дэлхийн тавцанд түлхэн гаргахад онцгой гавьяа байгуулсан “сартваахь” мөн.

ЗҮҮЛГИЙН НОМ ЗҮЙ

1. *Say-a-yin Geser-ün tuiji*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM Tomus IX, Fasc. 2, Шинжлэх ухаан, Дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл, Улаанбаатар, 1960, 192 т.х.
2. *CAMLING ŠENĀCIN-Ū NAMTAR ORUSIBA*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM, Tomus X, Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн Хэвлэл, Улаанбаатар, 1959, 233
3. *Nomči qatun's version of Kesar saga*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM Tomus IX, Fasc. 4, Эрдэм шинжилгээний хэвлэл, Улаанбаатар, 1960, 192 т.х.
4. *Билгүүн номч Бямбын Ринчен*. Эмхэтгэж эрхэлсэн Г.Аким, “Монгол уран зохиол” хэвлэлийн газар, Улаанбаатар, 1990, 238 т.х.
5. Лувсанжав Чой. *Насаараа дурсахуй* (ярилцлага). “Эрдмийн хэлхээ” цуврал No1, 2003, 95-108-р тал.
6. Ринчен Б. *Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл* (Мажаар улсаар явсан минь). Улаанбаатар, 1958, 209 т.х.
7. Ринчен Б. *Из нашего культурного наследия* (сборник статей). Улан-Батор, 1958, 171 с.
8. Ринчен Б. *Культ исторических персонажей в монгольском шаманстве*. –В кн.: Сибирь, Центральная и Восточная Азии в средние века. –Нобосибирск: Наука, 1975, с. 188-195
9. Ринчен Б. *Манай ардын туульс*. “Монгол ардын баатарлаг туульсын учир” номд, Эмхэтгэсэн У.Загдсүрэн, редактор С.Лувсанвандан, ШУА-ийн хэвлэл, Улаанбаатар, 1966, 127 т.х.

10. Ринчен Б. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*, I боть (Монгол хэл бичгийн ухаан). Ариутган хянасан академич Ринчений Барсболд, -Улаанбаатар, 2011. 200 т.х.
11. Ринчен Б. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*, II боть (Монгол утга зохиол судлал). Ариутган хянасан академич Далантайн Цэрэнсодном, -Улаанбаатар, 2011. 204 т.х.
12. Rintchen B. Folklore Mongol. - *Asiatische Forschungen*. Bd 7, 11, 12, 15, Wiesbaden: Harrassowitz, 1960, 1963, 1964, 1965
13. Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. I. Sources littéraires, Wiesbaden: Otto Harrassowitz, 1959, 124 p. [Asiatische Forschungen, Band 3]
14. Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. II. Textes chamanistes bouriates, Wiesbaden: Otto Harrassowitz, 1961, 156 p. [Asiatische Forschungen, Band 8]
15. Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. III. Textes chamanistes mongols. Wiesbaden: Otto Harrassowitz, 1975, 151 p. [Asiatische Forschungen, Band 40]